



ГОВСУМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/1

Баянтал сум

Газар өмчлөх эрхийг дуусгавар болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 заалтыг тус тус үндэспэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Хулст овогт Адъяасурэнгийн Шинэбаяр (ЕЙ90031119) нь тус сумын 1 дүгээр багийн Лүн 1-130 тоот хаягт сумын Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/47 дугаартай захирамжийн 1 дэх хэсэгт өмчилсөн газраа цуцлах хүсэлт гаргасан тул газар өмчлөх эрхийг дуусгавар болгосугай.

2. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж, өмчлөх эрхийг дуусгавар болгосон газрыг хүлээн авахыг сумын Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/47 дугаар захирамжийн 1 дэх иргэний газар өмчлөх эрхийг дуусгавар болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА
ГАНХБАЯР



ОВСҮМБЭР АЙМАГ
БАЯНГЛС СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1/2023

Баянтал сум

Газар өмчлөх эрхийг дуусгавар болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Умба тайж Хулст овогт Цэвээндоржийн Орхон (ЕЙ70071706) нь тус сумын 1 дүгээр багийн Лүн 4-440 тоот хаягт сумын Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/47 дугаартай захирамжийн 56 дахь хэсэгт өмчилсөн газраа цуцлах хүсэлт гаргасан тул газар өмчлөх эрхийг дуусгавар болгосугай.
2. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж, өмчлөх эрхийг дуусгавар болгосон газрыг хүлээн авахыг сумын Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/47 дугаар захирамжийн 56 дахь иргэний газар өмчлөх эрхийг дуусгавар болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Г.АНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН
БАЯНТАЛ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1/23

Баянтал сум

Газар эзэмших эрхийг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

- Тус сумын 1-р баг Их Уулын өвөр байрлах өвөлжөөний зориулалтаар эзэмшиж буй иргэн Адъяагийн Замзаах (ЗН84050412), 4203002516 тоот нэгж талбарын дугаар бүхий 700м² газрын газар эзэмших эрхийн хугацааг 15 жилийн хугацаатайгаар сунгаж эзэмшүүлсүгэй.
- Газар эзэмших эрхээ сунгуулсан иргэн А.Замзаахын газар эзэмших гэрээг шинээр байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, ажиллахыг сумын Газрын даамал (Л.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  ГАНХБАЯР



ОВЬСУМБЭР АЙМАГ
БАЯНТА СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 4/08

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр ээлжийн хурлаар дэмжигдсэн төсөл арга хэмжээнүүдийн төсвийг хавсралтаар баталсугай.
2. Дээрх зардалд шаардагдах 7,565,000 (долоон сая таван зуун жаран таван мянга) төгрөгийг сумын байгаль орчныг нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын няглан бодогч (Х.Ариунгуяа)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

Засаг даргын 2023 оны 01-р сарын 10-ны өдрийн

10/04 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	ТӨСӨВТ ӨРТӨГ
1	Туурь хог хаягдал цэвэрлэх	4,000,000
2	Нөхөн сэргээх зардал /мод тарих/	2,500,000
3	Шатахууны зардал	1,065,000
Бүгд		7,565,000



БАЯНТАЛ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 2105

Баянтал сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.16 дахь заалт 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугаар зүйлийн 30.1, 52 дугаар зүйлийн 52.7 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 07 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Газар эзэмших хүсэлт гаргасан иргэн Булгууд овогтой Ганболдын Уганбат (ЗЮ96110912)-т 1 дүгээр баг “Цахарын энгэр” хэмээх газрыг өвөлжөөний газрын зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрх олгосугай.
- Дээрх газар эзэмших эрх авсан иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын төлбөр тооцох, газрын улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА
ГАНХБАЯР



ОӨЛСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАГ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Ду аар A/06

Баянтал сум

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл,
арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх,
зөвлөгөө өгөх ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 2024 онд хийж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх, зөвлөгөө өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

(Худалдан авах ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн)

Гишүүд:

(Санхүү албаны дарга)

(Байгаль орчин хамгаалагч ажилтан)


(Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн)

(Ахмадын хорооны дарга)

(Иргэний төлөөлөл)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх баг, хорооны ИНХ-аас ирүүлсэн тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг бэлтгэн сумын Засаг даргын зөвлөлд 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай..

3. Энэ захирамж гарсантай холбооулан сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн A/16 дугаар захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай



D:/My Documents/2023 ajil/zahiramj.doc

421230018

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ
ЗАХИРГААНЫ ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖЛАХ

2023 01 17

№02

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3 дахь хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35/А/10/9 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч, Соёлын төвийн эрхлэгч, Эрүүл мэндийн төвийн дарга нарын ажлын ур чадварыг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

(Сумын Засаг даргын Тамгын газрын

Санхүү албаны дарга)

Гишүүн:

(Аймгийн Боловсрол, Шинжлэх ухааны

Газрын сургалт арга зүй хариуцсан ахлах

арга зүй хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

(Сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого,

Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч, Соёлын төвийн эрхлэгч, Эрүүл мэндийн төвийн дарга нарын ур чадварын нэмэгдлийг холбогдох хууль журмын дагуу бодож олгохыг Ерөнхий боловсролыч сургуулийн нягтлан бодогч (Ц.Жаргалмаа), Соёлын төвийн нягтлан бодогч (Х.Ариунгуа), Цэцэрлэгийн нягтлан бодогч (Х.Ариунгуа), Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч (Б.Амартувшин) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА
ГАНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ
БАНГАЛ СҮМННЫ ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

номер A/08

Бангалт тус

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар хуралдаанаар дэмжигдсэн төсөл арга хэмжээнүүдийн төсвийг хавсралтаар баталсугай.
2. Дээрх зардалд шаардагдах 3,664,500 (гурван сая зургаан зуун жаран дөрвөн мянга таван зуу) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас зарцуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын санхүү албаны өрөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуяа)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.АНХБАЯР

Засаг даргын 2023 оны 01-р сарын 30-ны өдрийн

108 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	ТӨСӨВТ ӨРТӨГ
1	Нутгийн өөрөө удирдлага үүсч хөгжсний 30 жил	2,000,000
2	Сумын тэргүүний байгууллага, ажилтан, ажилчин	550,000
3	Засаг даргын нэрэмжит тэмцээний шагнал	1,114,500
Бүгд		3,664,500



ГОВСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар A/09

Баянтал сум

Сүмүн Засаг даргын зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын дэргэд байнгын ажиллах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Гишүүд:

Засаг даргын орлогч дарга

Засаг даргын Тамгын газрын дарга

Лүн багийн Засаг дарга

Их уул багийн Засаг дарга

Санхүү албаны дарга

Ерөнхий боловсролын сургуулийн захирал

4 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч

Соёлын төвийн дарга

“Талын илч” ОНӨААТҮГазрын дарга

Ахмадын хорооны дарга

Нийгмийн бодлого, худалдан авах

ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

2. Зөвлөлийн хурлын журмыг хавсралт ёсоор баталж, дагаж мөрдсүгэй.

3. Зөвлөлийн хуралдах хуваарь, хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлдэж, хурлын зохион байгуулалтаар хангаж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн A/17 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА ГАНХБАЯР

Баянтал сумын Засаг даргын оны
..... сарын өдрийн дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1. Сумын Засаг дарга бүрэн эрээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, орон нутгийн захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангах, ажлын үр дүн, үр нөлөө, тулгамдсан асуудлуудыг зөвлөлдөн шийдвэрлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Нийтлэг үндэслэл

- 2.1. Сумын Засаг дарга нь дэргэдээ Засаг даргын зөвлөлтэй байна.
- 2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлыг Засаг дарга зарлан хуралдуулах бөгөөд хурлыг удирдана. Засаг даргын эзгүйд Засаг даргын орлогч хурлыг удирдана.
- 2.3. Зөвлөлийн гишүүд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийн дагуу асуудлыг чөлөөтэй хэлэлцэх бөгөөд Засаг даргад зөвлөх эрхтэйгээр хуралд оролцно.
- 2.4. Зөвлөлийн гишүүдийн олонх сролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 2.5. Зөвлөлийн гишүүд хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй бол Засаг даргад урьдчилан мэдэгдэж чөлөө звна.
- 2.6. Зөвлөлийн хуралд асуудал эруулж буй албан тушаалтан тухайн асуудлыг өөрийн биеэр танилцуулж, шийдвэрийн кэрэгжилтийг хангана.

Гурав. Хурлын бэлтгэл хангах

- 3.1. Зөвлөлийн Хурлын зохион байгуулалт, техникийн болон бусад бэлтгэл ажлыг Тамгын газрын дарга болон Хууль эрх зүйн, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн хариуцан зохион байгуулна.
- 3.2. Хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах тасаг, байгууллагууд холбогдох танилцуулга, мэдээллийг бэлтгэн сумын Засаг даргын Тамгын газрын харьяа мэргэжилтэнүүдэд хянуулан, хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан хаагч, ажилтанд ирүүлнэ.
- 3.3. Хурал хариуцсан ажилтан хурлаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн танилцуулга, мэдээлэлд үндэслэн хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний төслийг боловсруулан, Тамгын даргаар хянуулж, хурал болохоос 1-ээс доошгүй хоногийн өмнө Засаг даргад танилцуулна.
- 3.4. Хурлын хэлэлцэх асуудлын дараалалд ороогүй, хурлаар зайлшгүй хэлэлцэх асуудлыг хурал даргалагчийн зөвшөөрснээр нэмж оруулон хэлэлцүүлнэ.

3.5. Хуралд хэлэлцүүлэхээр Засаг даргын Тамгын газарт ирүүлэх материалын бүрдүүлэлт нь үндэслэл тооцоо, судалгаа, хуралд оруулах шийдвэрийн төсөл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хуралд асуудал оруулж байгаа албан тушаалтан хариуцна. Хурлаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн материалыг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.

3.6. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох тасаг, харьяа газар, албан хаагчид оролцож болно.

Дөрөв. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал

4.1. Зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

4.1.1. Засаг даргын бүрэн эрхтэй холбогдох хууль, тогтоомжид заасан асуудал

4.1.2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал

4.1.3. Зөвлөлийн гишүүдийн боловсруулсан санал, төслүүд

4.1.4. Засаг даргын нөөц хөрөнгөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1.5. Засаг даргаас олгох шагнал

4.1.6. Орон нутгийн санхүү, төсөв, хөрөнгө

4.1.7. Сумын ойрын болон дунд хугацааны хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээг зохион байгуулах тухай

4.1.8. Сумын төсвийн байгууллагууд болон орон нутгийн өмчид байгууллагуудын авч хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн, дүгнэлт

4.1.9. Иргэд, иргэний нийгмийн байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт

4.1.10. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхий сайдын захирамж, шийдвэр болон бусад дээд шатны албан тушаалтан, түүнчлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн болон сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Засаг даргын тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр хэлэлцэнэ.

4.1.11. Засаг даргаас Багийн Засаг дарга, байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал нартай байгуулсан гүйцэтгэлийн гэрээ, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн тайлан, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээ зэргийг хэлэлцэж санал хүргүүлнэ.

4.1.12. Сумын хэмжээнд тулгамдсан асуудлууд.

Тав. Хурал зохион байгуулах, шийдвэр гаргах

5.1. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлын зохион байгуулалтыг хариуцан зөвлөлийн гишүүдийн ирцийг бүртгэж, танилцуулна.

5.2. Хурал даргалагч хурлыг нээж тухайн өдрийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг танилцуулан, зөвлөлийн гишүүдээс санал авч, дарааллын дагуу хэлэлцүүлнэ.

5.3. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг оруулах танилцуулгыг зураг, видео бичлэг, биет зүйлс, түүний загвар, төсөл байдлаар хийж болно.

5.4. Зөвлөлийн гишүүд хурлаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авна.

5.5. Хурлаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсон асуулт, хариултыг дуусгасны дараа хурал даргалагчийн зөвшөөрснөөр зөвлөлийн гишүүд нэг асуудлын талаар хоёроос илүүгүй удаа санал гаргана. Нэг удаа санал гаргах, үг хэлэх хугацаа тухай бүр 3 минутаас хэтрэхгүй байна.

5.6. Засаг дарга зөвлөлийн гишүүдээс тухайн асуудлаар санал хурааж, шийдвэр гаргана. Зөвлөлийн хурлаас гарах шийдвэр нь тэмдэглэл хэлбэртэй байна.

5.7. Хурлын зохион байгуулалт хариуцсан албан хаагч нь хурлын явцын талаарх тэмдэглэлийг дуу хураагуурт бичиж, хэвлэмэл хуудсан дээр **ажлын 1-3 хоногт** багтаан буулгаж, хурлын тэмдэглэлийг Засаг даргын Тамгын газрын даргаар хянуулан, Засаг даргаар гарын үсэг зуруулж, баталгаажуулан хүргүүлэх.

5.8. Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нь хурлын хэлэлцэх асуулал, гарсан шийдвэрийг тухай бүр www.Bayntal.qs.gov.mn цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сурталчлах, таниулах ажлыг хариуцна.

5.9. Зөвлөлийн гишүүд хурлын үеэр гар утсаар ярих, хурал даргалагчийн зөвшөөрөлгүйгээр орж, гарахыг хориглоно.

Зургаа. Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих

6.1. Хурлын зохион байгуулалтыг хариуцсан нарын бичгийн дарга өмнөх хурлаас гарсан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн явцын мэдээллийг бэлтгэн Засаг даргын Тамгын газрын даргад, тамгын дарга зөвлөлийн хуралд танилцуулж, үр дүнг тооцно.

6.2. Зөвлөлийн хурлын явцад Засаг даргын Тамгын газрын дарга хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.



ГӨВСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СҮМЬИН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 4/10

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Төсвийн тухай хууль 16 дугаар зүйл. Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрхийн тухай хуулийн 16.5.5. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамын 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.6, 4.1, 4.2 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар ээлжийн хурлаар дэмжигдсэн төсөл арга хэмжээнүүдийн төсвийг хавсралтаар баталсугай.
2. Дээрхи зардалд шаардагдах 50,000,000 (тавин сая) төгрөгийг 2023 оны Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.
3. Тус ажлын хэрэгжилтийг хангуйлж хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д даалгасугай.

ДАРГА ГАНХБАЯР

Сумын Засаг даргын 2023 оны
дүгээр сарын 31, өдрийн 11 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

Туурь хог хаягдалд зарцуулагдах 50,000.00 төгрөгийн
задаргаа

№	Зарцуулах төрөл	Үнэ
1.	Төв хогийн цэг	15,000.0
2.	Мод бут авах, суулгах, арчлах, урамшуулах	10,000.0
3.	152,154-р байрны ногоон байгууламжийн хашааг өндөрсгөх, сайжруулах	10,000.0
4.	Шатахуун	5,000.0
5.	Туурь хог хаягдал, нохой устгал	5,000.0
6.	ЗДТГ-ын дээврийн засвар	5,000.0
7.	Бүгд	50,000.0